



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/284

Хэрлэн сум

Хүн ам, орон сууцны завсрын тооллогын төсвийн хуваарь баталж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, Хүн ам орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хуралдааны 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн ам, орон сууцны 2015 оны ээлжит завсрын тооллогын зарцуулах төсвийн хуваарийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулж, Хүн ам, орон сууцны 2015 оны ээлжит завсрын тооллогыг чанартай үр дүнтэй хууль журмын дагуу явуулахыг аймгийн тооллогын комиссын орлогч дарга буюу Статистикийн хэлтсийн дарга /Д.Болдбаатар/-д даалгасугай.

Гурав. Хүн ам, орон сууцны 2015 оны ээлжит завсрын тооллогын төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Хэрлэнчимэг/-д, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Болд/-д тус тус даалгасугай.



Ж.ОЮУНБААТАР

Аймгийн засаг даргын 2015 оны  
 ... дугаар сарын ... Өдрийн  
 А.Б.Б. Дугаар захирамжийн хавсралт

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2015 ОНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ**

Д/д	Нэр төрөл	2015 онд шаардагдах төсөв /мян.төг/	Хувиарлах сар	Тайлбар
<b>1. Орон нутгийн төсвөөс гаргах зардал</b>				
1	Завсрын тооллогын үеийн үйл ажиллагааны зардал	39000.0	6, 7, 8, 9, 10, 11-р сард	ХАӨМС-г баяжуулах ажлын хүрээнд гэрээт цалин холбооны зардал. Гэрээт ажилтны цалин сард 450,000 төгрөг бөгөөд НДШ 11%, хувь хүний 10%, ХАОАТ-ын 10% суутгана.
2	Тоолох үеийн тоологчийн унааны зардал	10560.0	6, 7, 8-р сар	ХАӨМС-г баяжуулах ажлын хүрээнд гарах унааны зардал. 1 багт 160 км, км бүрийг нь 750 төгрөгөөр тооцно.
3	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр хэвлэх	6960.0	6-р сар	Бичгийн цаас, принтерийн хорны зардал
<b>2. Сум, дүүрэг, баг, хорооны түр товчооны үйл ажиллагааны зардал</b>				
4	Бүх шатны сургалтын зардал	12050.2	6-р сар	Аймаг, нийслэл, сум, дүүрэг баг, хорооны ажилчид болон гэрээт ажилтаны сургалтын зардал. Сургалтын зардалд сургалтын материал, хоолны мөнгө, сум багийн ажилчдын томилолтын зардлууд багтана.
5	Тооллогын суртчилгааны зардал	9192.6	6, 7, 8-р сар	Завсрын тооллогын бүх шатны суртчилгааны зардал.
6	Тоног төхөөрөмжийн зардал	8200.0	6-р сар	Орон нутгийн статистикийн хэлтсийн тоног төхөөрөмж шинэчлэлтийн /Компьютер, хувилагч машин/ зардал
7	Засвар үйлчилгээний зардал	4500.0	6-р сар	Засвар үйлчилгээний зардал /Машины сэлбэг, засвар/
8	Вирусын эсрэг програмын зардал	3180.0	11-р сар	Багын засаг дарга нарын компьютерт суулгах вирусын программ
9	Мониторинг хийх зардал	1953.8	9, 10-р сар	Тухайн засаг захиргааны нэгж болон харуцсан нэгжээс аймгийн болон суманд мониторинг хийх зардал
10	Хяналтын тооллого	4675.0	10, 11-р сард	Хяналтын тооллогын тоологчийн хоол, холбоо, томилолт, унааны зардал
<b>Нийт дүн</b>		<b>100271.6</b>		